



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.3, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аэродром цэвэрлэгээний автомашин /Дэглий цагаан, Гурвансайхан, ГТҮШХА нийт 3 ширхэг/ нийлүүлэх ИНЕГ/ХО/ТББ/Б-45/20 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Д.Маралхүү

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дэд дарга

Гишүүд:

Ц.Цэдэв

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Техник үйлчилгээ, засварын хэлтсийн дарга

Б.Гантулга

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Техник үйлчилгээ, засварын хэлтсийн засварын инженер

Э.Энхжин

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Х.Баярмаа

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны ерөнхий нягтлан бодогч

2. Дээрх ажлыг гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээн авах комисс /Д.Маралхүү/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ